

АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ ХХК

2025

ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН



АГУУЛГА

01.

Компанийн товч танилцуулга

02.

Үйл ажиллагааны тойм

03.

Компанийн засаглал, тогтвортой
хөгжил

04.

Эрсдэлийн удирдлага, дотоод
хяналт

05.

Эдийн засаг, зах зээлийн орчны
тойм

01 КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ашид Ассет Менежмент” ХХК нь 2021 онд байгуулагдан Санхүүгийн Зохицуулах Хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна. ХОМК нь хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд харилцагчдын хөрөнгийг үр ашигтай удирдах, урт хугацаанд үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани нь санхүүгийн зах зээлд ил тод байдал, хариуцлагатай засаглал, мэргэжлийн ёс зүйг баримтлан ажилладаг.

2025 онд компани нь үндсэн үйл ажиллагаагаа бэхжүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын баазыг тэлэх, зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэн ажиллав.

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭРХЭМ ЗОРИЛГО | MISSION

Хүн бүрийг хөрөнгө оруулагч болгож хамтын үнэ цэнийг бүтээнэ.

Building shared value, helping everyone to be an investor.

АЛСЫН ХАРАА | VISION

Хүртээмжтэй, хялбар, хариуцлагатай үйлчилгээг хөгжүүлэх замаар оролцогч талуудын итгэлийг хүлэсэн Нөлөөллийн хөрөнгө оруулалтын тэргүүлэгч компани болно.

A leading impact investing company that is trusted by all stakeholders in its commitment to develop inclusive, simple(easy) and responsible investment management services.

УДИРДЛАГЫН МЭНДЧИЛГЭЭ

2025 он нь дэлхийн болон дотоодын санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал, өөрчлөлт ихтэй жил байсан хэдий ч манай компани стратегийн зорилтоо тууштай хэрэгжүүлж, тогтвортой өсөлтийг хангахад чиглэн ажилласан.

Бид харилцагчдын итгэлийг хамгийн чухал үнэт зүйл хэмээн үзэж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад судалгаа шинжилгээнд суурилсан, хариуцлагатай хандлагыг баримталж ирсэн. Тайлант хугацаанд бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, шинэ боломжуудыг нээх, зах зээлийн нөхцөлд нийцсэн хөрөнгө оруулалтын шийдлүүдийг санал болгоход анхаарлаа төвлөрүүлсэн болно.

Цаашид бид нөлөөллийн хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх, тогтвортой өсөлтийг дэмжих, харилцагчдад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилтоо улам бататган ажиллах болно

02 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ЗАСАГЛАЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

- Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлыг тогтмол хийж холбогдох шийдвэрүүдийг гаргаж хэвшсэн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороод болон бусад хороодын үйл ажиллагааг дараагийн шатанд гаргахаар төлөвлөж байна.
- Бүтэц зохион байгуулалтын хувьд үндсэн хөдөлмөрийн гэрээтэй 5 ажилтан, гэрээт 1 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулав.
- Мөн онд програм хангамж хөгжүүлэлт, хууль зүйн үйлчилгээ, маркетинг болон хэрэглэгчтэй харилцах чиглэлээр мэргэшсэн компаниудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж ирлээ.
- Үндсэн 5 ажилтан нь хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн сертификаттай байна.
- Цаашид ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэх зорилгоор бодлогын түвшинд холбогдох арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



У.ЭНХТАЙВАН

ТУЗ-ийн дарга

Эдийн засагч, Санхүүч мэргэжилтэй, 2011 онд Японы Мэйкай их сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд Японы Жюүшин ХК-д удирдах төвшин хүртэл дэвшин 11 жил ажилласан туршлагатай.

Монголдоо ирээд Гүүдсек ҮЦК ХХК-г хамтран байгуулж одоогоор компанийн гүйцэтгэх захирлын албыг хашдаг чадварлаг эдийн засагч юм. МҮЦАЭХ олгодог хөрөнгийн зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхтэй, Санхүүгийн Зохицуулах Хорооны “тохиромжтой этгээд”-ийн шаардлагыг бүрэн хангасан.



Г. ЗОЛЖАРГАЛ

ТУЗ-ийн гишүүн

Certified ESG Analyst (CESGA).

Хитоцубашигийн Их сургуульд менежментийн чиглэлээр бакалавр, Санхүүгийн чиглэлээр магистр хамгаалсан.

MCS групп, үндэстэн дамнасан Мицубиши корпорацийн Монгол, Сингапур дахь салбарт 10 жил ажилласан туршлагатай нэгэн юм.

2020 оноос эхлэн ESG, нөлөөллийн хөрөнгө оруулалт, Уур амьсгалын ногоон хөрөнгө оруулалтын корпорац, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй төслүүдэд зөвлөж ирсэн. Тэрээр Мэргэшсэн ESG аналит (CESGA) цолыг Монголоос ганцаар эзэмшдэг.



Ш. ТҮМЭНБАЯР

ТУЗ-ийн гишүүн

2008 онд Irish American University-г Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсөж 2016 онд ACCA буюу Олон улсын нягтлан бодогч цолыг авсан. Тэрээр Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны үнэмлэх, мөн Ирландын Банкируудын холбоо, Хуульч нарын холбооны тус тус мэргэжлийн үнэмлэхтэй.

Банк, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр JPMorgan хөрөнгө оруулалтын сан, SMBC aviation capital зэрэг олон улсын томоохон компаниудад 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд одоогоор Хас банкны Санхүүгийн газрын захирлын үүргийг гүйцэтгэдэг.

02 төлөөлөн удирдах зөвлөл



Э. БААСАН

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бизнесийн удирдлага чиглэлээр Анод банк, Худалдаа хөгжлийн банк, Юнител групп зэрэг байгууллагуудад удирдах төвшний ажлыг 20 гаруй жил гүйцэтгэж байгаа туршлагатай.

Одоогоор Юнител группийн үндсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны захирлын албыг хашдаг. Тэрээр бизнесийн удирдлага, хэрэглээний математикийн бакалавр зэрэгтэй.



Ш. ТҮМЭНБАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн

2006 онд Орос улсын MGIMO их сургуульд эдийн засгийн бакалавр мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд Японы Хитоцубаши Их сургуульд мэргэжил дээшлүүлж нийтийн бодлого чиглэлээр магистр хамгаалсан.

СЗХ, Хөгжлийн банк, DBM ассет менежмент зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад эдийн засаг, нийтийн бодлогийн чиглэлээр хяналт шалгалт, зөвлөгөө өгөх түвшинд 15 жил ажилласан туршлагатай.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



03 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

СЗХ-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн № 145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсаны дагуу Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК нь ТУЗ-ийн 2022 оны 07 сарын 20-ны өдрийн 7/11 тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

СЗХ-оос ирсэн чиглэл, үүрэг даалгаврын дагуу хэрэгжилтийн тайланг тухай бүр шинэчлэн засаглалын зэрэглэлээ ахиулан ажиллахаар зорьж ажиллана.

Компанийн засаглалын кодексийн өөрийн үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 90.28% буюу засаглал сайн, эрсдэлгүй ангилалд багтаж байна.

№	Гарчиг	Авбал зохих оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	91.60%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83.30%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	87.50%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	83.30%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	87.50%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%
	Нэгдсэн дүн	72	65	90.28%

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компани нь үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зарчмыг баримталж, байгаль орчин, нийгэм засаглалын (ESG) хүчин зүйлсийг харгалзан үзэн ажиллахыг зорьдог. Хөрөнгө оруулалт менежментийн компанийн хувьд байгаль орчинд үзүүлэх шууд нөлөөлөл харьцангуй бага боловч нөөцийн зохистой хэрэглээ, хариуцлагатай үйл ажиллагааг дэмжихэд анхаарч ажилласан.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

“Ашид Ассет Менежмент” ХХК нь ажилтнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, аюулогүй, эрүүл орчныг бүрдүүлэх, тэгш боломжийг хангах зарчмыг баримтлан ажилласан. Тайлан хугацаанд ажилтнуудыг мэргэжлийн болон ур чадварын сургалтанд хамруулж, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангах, үнэн зөв мэдээллээр шуурхай хангах нь компанийн нийгмийн хариуцлагын ухал хэсэг бөгөөд тайлант хугацаанд холбогдох мэдээллийг компанийн цахим хуудас болон бусад сувгаар тогтмол мэдээллэсэн.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

компани нь урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах зорилгоор сайн засаглал, эрсдэлийн зохистой удирдлага, ил тод байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үйл ажиллагааныхаа үндсэн зарчим болгон ажиллаж байна. Цаашид ESG хүчин зүйлсийг үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг дэмжих, оролцогч талуудын итгэлцлийг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжүүлэн ажиллана.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлж, цаасан баримт бичгийн хэрэглээг бууруулах, цахим архив, цахим мдээлэл солилцооны системийг ашиглах замаар нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжин ажиллав.

Мөн эрчим хүчний зохистой хэрэглээг хэвшүүлэх, ажилтнуудын байгаль орчны талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.

03 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд Ашид Ассет Менежмент ХХК нь хөрөнгө оруулалтын менежментийн үндсэн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, харилцагчийн хүрээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг баяжуулах чиглэлээр идэвхитэй ажилласан байна.

Компанийн зүгээс “Нордстэпп хувийн хөрөнгө оруулалтын сан” болон “Ашид Бондс тогтмол өгөөж хувийн хөрөнгө оруулалтын сан”-г зах зээлд нэвтрүүлж, нийт 23,6 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна. Мөн стратегийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд уулзалт, танилцуулах ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Хөрөнгө оруулалтын баг нь зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн активын хуваарилалтыг оновчтой хийж, эрсдэлийг удирдах бодлогыг тууштай хэрэгжүүлж байна. Компанийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын сангууд нь зах зээлийн хэлбэлзэлтэй нөхцөлд ажилласан хэдий ч харьцангуй тогтвортой гүйцэтгэлийг үзүүлсэн.

Ашид Арвижих хамтын хөрөнгө оруулалтын сан нь тайлант хугацаанд 12.8 хувийн өгөөж үзүүлж, харьцуулах үзүүлэлт болох 12.3-аас 0.77 нэгж хувиар давсан гүйцэтгэлтэй ажилласан байна. Тус сангийн хувьд 3 төрлийн активт түлхүү хөрөнгө оруулалт хийсэн нь гүйцэтгэлд голлон нөлөөлсөн.

Мөн Монложистикс Ирээдүй хувийн хөрөнгө оруулалтын сан нь 7.5 хувийн өгөөжтэй ажиллаж, хөрөнгийн бүтэц, эрсдэлийн түвшинг оновчтой хадгалж чадсан.

Тайлант хугацааны эцэст компанийн нийт удирдаж буй хөрөнгийн хэмжээ 21.2 тэрбум орчим төгрөгт хүрч, өмнөх оноос 17 дахин өссөн үзүүлэлттэй байна.

**Ашид Арвижих
Хамтын ХОС**

788.3 сая ₮

**Монложистикс Ирээдүй
Хувийн ХОС**

1.02 тэрбум ₮

**Нордстэпп
Хувийн ХОС**

19.4 тэрбум ₮

03 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



**“Ашид ассет менежмент” ХХК
Хараат бус Аудиторын тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр**



03 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нарны зам-62, ЮНЕСКО-гийн гудамж,
Юнион билдинг Б блок, 14 давхар, В-1403 тоот
Цахим шуудан хаяг: info@shonkhoraudit.mn
Цахим хаяг/Вебсайт: www.shonkhoraudit.mn
Холбоо барих утас: 976 8011-0088

2026.03.26 № 26/29

Танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Ашид Ассет Менежмент” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Ашид Ассет Менежмент” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.



Russell Bedford
taking you further

ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
АУДИТ | НББ | ТАТВАР | ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
Хараат бус мэргэжлийн фирмүүдийн дэлхийн сүлжээ болох Рассел Бедфорд Интернэшиллын гишүүн.

03 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.



ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
АУДИТ | НББ | ТАТВАР | ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
Хараат бус мэргэжлийн фирмүүдийн дэлхийн сүлжээ болох Рассел Бедфорд Интернэшнлийн гишүүн.



03 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ


Д.ШИЙРЭВ



Russell Bedford
taking you further

ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
АУДИТ | НББ | ТАТВАР | ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
Хараат бус мэргэжлийн фирмүүдийн дэлхийн сүлжээ болох Рассел Бедфорд Интернэшнлийн гишүүн.



03 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН 2025 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"Ашид ассет менежмент" ХХК	(төгрөгөөр)	
Балансын зүйл	2025.12.31	2024.12.31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	48,011,539.1	25,285,647.4
Дансны авлага	73,497,319.0	9,100,935.8
Бусад авлага	4,406,318.4	23,667,873.4
Бараа материал	-	6,939,400.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	77,727,004.6	77,727,004.6
Бусад эргэлтийн хөрөнгө	68,780.0	68,780.0
Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>203,710,961.0</u>	<u>142,789,641.1</u>
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	33,215,513.3	38,919,893.3
Биет бус хөрөнгө	212,824,735.0	218,605,482.4
Урт хугацаат хөрөнгө оруулалт	76,832,080.0	87,477,700.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>322,872,328.4</u>	<u>345,003,075.8</u>
Нийт хөрөнгийн дүн	<u>526,583,289.4</u>	<u>487,792,716.9</u>
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	47,654,184.9	26,002,534.6
Цалингийн өглөг	1,173,834.4	3,585,959.1
Татварын өр	6,178,058.8	5,798,772.4
НДШ - ийн өглөг	5,315,984.7	3,391,341.1
Богино хугацаат зээл	55,000,000.0	-
Бусад богино хугацаат өр төлбөр	164,387,863.2	90,754,961.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	<u>279,709,926.0</u>	<u>129,533,568.1</u>
Өр төлбөрийн нийт дүн	<u>279,709,926.0</u>	<u>129,533,568.1</u>
Эздийн өмч		
Өмч		
Хувийн өмч	800,000,000.0	800,000,000.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	7,218,000.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	87,909.8
Эздийн өмчийн бусад хэсэг	590,000,000.0	453,805,000.0
Хуримтлагдсан ашиг	(1,143,126,636.7)	(902,851,761.0)
Эздийн өмчийн дүн	<u>246,873,363.4</u>	<u>358,259,148.8</u>
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	<u>526,583,289.4</u>	<u>487,792,716.9</u>

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрөнгийн зах зээлд нөлөөлөх макро эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэлтэй системийн эрсдэл олно улсын түвшинд өндөр хэвээр буй бөгөөд “Ашид Ассет Менежмент” ХХК-ийн хувьд хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлагын арга хэмжээг оновчтой хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хөрвөх чадвар, багцын эрсдэлийн удирдлагыг сайжруулахад төвлөрөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн стратегийн болон үйл ажиллагааны зорилго, зорилтоо биелүүлэх явцад учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэлийн улмаас гарах алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах, түүнээс үр ашигтай гарах замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, бодлогыг тодорхойлох, хянах зорилгоор Эрсдэлийн удирдлагын хороо болон Хөрөнгө оруулалтын хороог байгуулж тогтмол хуралдан шийдвэр гаргаж ажиллаж байна.

ДОТООД ХЯНАЛТ

Ашид Ассет Менежмент ХХК нь үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай засаглалыг хангах зорилгоор дотоод хяналтын тогтолцоог тасралтгүй хөгжүүлэн ажиллаж байна. Компанийн дотоод хяналтын тогтолцоо нь эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны үр ашиг, хууль, журмын нийцлийг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг бөгөөд тайлант хугацаанд дотоод хяналтын хүрээнд дараах үндсэн чиглэлүүдэд анхааран ажилласан. Үүнд:

- Компанийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагад нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих;
- Дотоод бодлого, журмын хэрэгжилтийг сайжруулах;
- Үйл ажиллагааны эрсдэлийг эрт илрүүлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Мөн дотоод хяналтын нэгж нь ХОМК болон сангуудын үйл ажиллагаанд нийт 8 удаагийн хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, сайжруулах шаардлагатай асуудлуудад холбогдох зөвлөмжийг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж, ТУЗ-д тайлагнан ажилласан байна.

Компанийн засаглалын хүрээнд шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч, удирдлагын түвшинд хяналт, тайлагналын тогтолцоог сайжруулсан бөгөөд комплаенсийн чиг үүргийг бэхжүүлэх хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) бодлого, журмын хэрэгжилтийг хангаж, холбогдох дотоод сургалт, мэдээллийг ажилтнуудад тогтмол хүргэж ажилласан. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дотоод хяналтыг сайжруулж, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Цаашид дотоод хяналтын тогтолцоог олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох, технологид суурилсан хяналтын шийдлүүдийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах болно.

05 ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: ХЯМДРАЛ УУ, ЭСВЭЛ “ШОК ДАХИН ҮРГЭЛЖЛЭХ” ҮЕ ҮҮ?

ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ ШИНЭ ШАТАНД ШИЛЖЛЭЭ

2026 оны эхний улиралд дэлхийн эдийн засагт шинэ төрлийн эрсдэлүүд бодитоор илэрч, зах зээлд нөлөөлж эхэллээ. Олон улсын байгууллагуудын сүүлийн төсөөллөөр дэлхийн эдийн засгийн өсөлт 2026 онд ойролцоогоор 2.7–3.0% байх төлөвтэй байгаа нь 2025 оны түвшинтэй ойролцоо боловч өсөлтийн чанар муудаж, доошлох эрсдэл нэмэгдсэн хэвээр байна. Геополитикийн хурцадмал байдал, эрчим хүчний үнийн өсөлт, худалдааны бодлогын зөрчил, инфляцын дарамт зэрэг нь эдийн засгийг илүү эмзэг орчинд шилжүүлж, өсөлтийг сааруулах гол хүчин зүйл болж байна.

АНУ-ын эдийн засаг харьцангуй тэсвэртэй хэвээр байгаа ч өсөлт саарах шинж ажиглагдаж эхэллээ. Тарифын бодлогоос үүдэн импортын зардал нэмэгдэж, компаниудын ашигт ажиллагаа болон хэрэглэгчийн худалдан авах чадварт дарамт үзүүлж байна. Үүний зэрэгцээ Ойрхи Дорнод дахь хурцадмал байдал, Ирантай холбоотой эрсдэлүүд нь газрын тосны нийлүүлэлтэд нөлөөлж, эрчим хүчний үнийг өсгөснөөр инфляц буурах хүлээлтийг сааруулж, дахин сэргэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Инфляц илүү “бүтцийн шинжтэй” болж буй энэ орчинд мөнгөний бодлого төвөгтэй болж, ХНС болон бусад төв банкуудын бодлогын орон зай хязгаарлагдаж байна. Ийнхүү дэлхийн эдийн засаг “өндөр хүү – бага өсөлт”-ийн орчинд шилжих эрсдэл нэмэгдэж байна.

Хөрөнгийн зах зээлд энэ өөрчлөлт шууд тусгалаа олж, S&P 500 индекс 2025 оны оргилоос буурсны дараа сэргэлт үзүүлэх оролдлого хийж байгаа ч хэлбэлзэл өндөр хэвээр байна. Технологийн салбар, ялангуяа хиймэл оюун ухаантай холбоотой компаниудын үнэлгээ өндөр түвшинд хадгалагдаж байгаа ч ашигт ажиллагаатай холбоотой эргэлзээ нь ханшийн савлагааг нэмэгдүүлж байна. Харин эрүүл мэнд, өргөн хэрэглээ, эрчим хүч зэрэг салбарууд харьцангуй тогтвортой гүйцэтгэл үзүүлж байна. Нөгөө талаас, эдийн засгийн өсөлт саарах хүлээлт болон эрсдэлээс зайлсхийх хандлага нэмэгдсэнээр бондын зах зээлд сонирхол дахин нэмэгдэж, урт хугацаат өгөөж буурах хандлага ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч инфляц дахин сэргэх эрсдэл нь өгөөжийг хязгаарлах гол хүчин зүйл хэвээр байна. Үүний зэрэгцээ худалдааны зөрчил, нийлүүлэлтийн сүлжээний өөрчлөлт, геополитикийн эрсдэлүүд нь дэлхийн эдийн засгийн суурь нөхцөлийг улам төвөгтэй болгож байна.

2026 оны эхний улиралд хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйд болгоомжлол давамгайлж, эерэг мэдээ богино настай, харин сөрөг мэдээлэл илүү хурдан үнэд шингэх хандлага ажиглагдаж буй хэдий ч үнэлгээ буурсан, тогтвортой мөнгөн урсгалтай компаниуд, инфляцаас хамгаалах шинжтэй хөрөнгө оруулалтууд урт хугацаанд илүү сонирхол татахуйц болж эхэлж байна. Ийм нөхцөлд хөрөнгө оруулагчид богино хугацаанд болгоомжтой байр суурь баримтлахын зэрэгцээ урт хугацаанд хөрөнгө оруулалтын багцаа уян хатан, тэнцвэртэй байлгах нь чухал хэвээр байна.

Дүгнэж хэлбэл, дэлхийн эдийн засаг хямралын гүн шатанд ороогүй ч өндөр өсөлтийн мөчлөгөөс гарч, илүү эмзэг, тодорхой бус орчинд шилжсэн байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд эрсдэлийг илүү нарийн үнэлж, өгөөжийн шинэ боломжийг эрэлхийлэх шаардлагатай үе шат болж байна.

05 ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: ГАДААД ОРЧНЫ СОРИЛТУУД БА ДОТООДЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

2026 оны эхний улирлын байдлаар Монголын эдийн засаг гадаад орчны эрсдэл нэмэгдсэн нөхцөлд өсөлтөө хадгалах, дотоод тогтвортой байдлыг хамгаалах сорилттой тулгарч байна. Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал, түүхий эдийн үнийн савлагаа, ялангуяа БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил сул хэвээр байгаа нь Монголын экспортод шууд нөлөөлсөөр байна. 2025 онд эдийн засаг харьцангуй тогтвортой байж, уул уурхайн салбар, тэр дундаа Оюутолгойн зэсийн экспортын өсөлтөөр дэмжигдэн 5.9% орчим өсөлт үзүүлсэн ч өсөлтийн бүтэц эмзэг хэвээр байна.

Гадаад валютын албан нөөц оны эцэст ойролцоогоор 7 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэн нь төгрөгийн ханшийн дарамтыг тодорхой хэмжээнд бууруулсан ч импортын өндөр хамаарал, ялангуяа шатахуун, өргөн хэрэглээний бараанаас шалтгаалсан эмзэг байдал хадгалагдсаар байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр 7-8% орчимд тогтворжсон инфляц 2026 оны эхэнд Ойрхи Дорнодын хурцадмал байдал, Ирантай холбоотой зөрчлөөс үүдэлтэй газрын тосны үнийн өсөлтөөр дамжин дахин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Шатахууны үнэ тэвээр, хүнс, өргөн хэрэглээний бараанд дам нөлөөлдөг тул инфляцыг суурь түвшинд хадгалах “cost-push” хүчин зүйл болж байна.

Монголбанк ны зүгээс инфляц болон ханшийн дарамтыг хязгаарлах зорилгоор хатуу бодлогын байр сууриа хадгалж, бодлогын хүү болон макро зохистой бодлогын хэрэгслүүдийг чангаруулсан хэвээр байна. Энэ нь ханшийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байгаа ч нөгөө талаас зээлийн өсөлт, хөрөнгө оруулалт, хувийн хэрэглээг сааруулах нөлөөтэй байна. Түүнчлэн түүхий эдийн үнийн савлагаа, экспортын орлогын бууралтаас шалтгаалан төсвийн орлогод дарамт үүсч, төсвийн сахилга бат чухал асуудал хэвээр байна. Ийм нөхцөлд дунд хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хадгалах, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх шаардлага улам нэмэгдэж байна.

Хөрөнгийн зах зээлийн хувьд мөнгөний хатуу бодлого, хөрвөх чадварын бууралт, хөрөнгө оруулагчдын итгэл сул байдал зэргээс шалтгаалан хувьцааны зах зээлийн гүйцэтгэл хязгаарлагдмал хэвээр байна. MSE Top 20 Index индексийн өсөлт саарч, зах зээлийн идэвхжил буурсан нь хөрөнгө оруулагчид хамгаалалтын стратегид шилжсэнийг илтгэж байна. Харин бодлогын хүү өндөр хэвээр байгаа нь бонд, хадгаламж зэрэг тогтмол өгөөжтэй хэрэгслийн сонирхлыг нэмэгдүүлж байна.

Үүний үр дүнд дотоодын зах зээлд хөрөнгө оруулалтын урсгал илүү болгоомжтой болж, эрсдэл багатай, өгөөж тогтвортой актив руу чиглэх хандлага давамгайлж байна. Өрийн хэрэгслийн өгөөжийн муруй эерэг хэлбэртэй хадгалагдаж байгаа нь хөрөнгө оруулалтын багцад тогтмол өгөөжтэй хэрэгслийн жинг нэмэгдүүлэх стратегийг дэмжиж байна.

Дүгнэж хэлбэл, Монголын эдийн засаг хямралын шатанд ороогүй ч гадаад орчны нөлөөнд эмзэг хэвээр байна. Ийм нөхцөлд хөрөнгө оруулагчдын хувьд өндөр өгөөж эрэлхийлэхээс илүүтэй эрсдэлийг удирдах, багцын тэнцвэрийг хадгалах, уян хатан стратеги баримтлах нь илүү оновчтой хэвээр байна.



Ашид - Ашигтай, Хүртээмжтэй

Холбоо барих

1504 тоот, Твин тауэр-1,
2-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар



+976-77661112



www.ashidasset.mn
info@ashidasset.mn